

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
Гүйцэтгэлийн удирдлагын баримт бичиг

**БАЙГУУЛЛАГЫН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ
ТАНИЛЦУУЛГА**

Байгууллагын нэр: **НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН
ГАЗРЫН ДАРГА

Б.ГАНХУЯГ

ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН
ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Н.БОЛОРМАА

2026 он

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2026 оны 06 дугаар сарын 12-ны өдөр

1.Хяналт- шинжилгээний зорилго:

Төсвийн ерөнхийлөн захирагч /Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд/-аас төсвийн төвлөрүүлэн захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-тай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, үйл ажиллгааг сайжруулах санал, зөвлөмж өгөх, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангахад оршино.

2.Арга, аргачлал:

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам” -ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний /2026 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар буюу хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр/ нэгтгэсэн явцын тайлан, мэдээ, мэдээллийг үндэслэн холбогдох албан тушаалтнуудаас тодруулга авах, ярилцлага хийх зэргээр тулган шалгах арга зүйг ашиглаж хэрэгжүүлэв.

3.Ерөнхий мэдээлэл:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 9 зорилтын 69 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 11 зорилтын 59 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, гадаад, дотоод харилцааг өргөжүүлж, ажил олгогч, даатгуулагчтай хамтран ажиллах” зорилгын хүрээнд 2 зорилт, 9 арга хэмжээ;
- “Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэн сангийн орлогыг бүрдүүлэн нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тогтвортой, бие даасан найдвартай байдлыг хангах замаар сангийн зарлагын гүйцэтгэлийг хангах, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал, хөнгөлөлт, чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд олгох, хяналт шалгалт, шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах” зорилгын хүрээнд 4 зорилт, 17 арга хэмжээ;
- Нийгмийн даатгалын үйлчилгээ, мэдээллийн нэгдсэн санг боловсронгуй болгож, дэвшилтэт шинэ технологи нэвтрүүлэх, олон нийтэд мэдээлэх, сурталчлах зорилгын хүрээнд 3 зорилт, 22 арга хэмжээ;

- “Даатгуулагч, үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд нийцсэн, нийгмийн хариуцлага бүхий тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх” зорилгын хүрээнд 2 зорилт 12 арга хэмжээ;

4.Үр дүн:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг харуулбал:

4.1.“**Бүрэн хангалттай**” буюу 85 буюу түүнээс дээш хувиар (арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн) үнэлэгдсэн 49 арга хэмжээ байна. Үүнд:

- 100 хувийн биелэлттэй 38 арга хэмжээ;
- 90 хувийн биелэлттэй 11 арга хэмжээ;

4.2.“**Хангалттай**” буюу 70 хувиар (шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах) үнэлэгдсэн 6 арга хэмжээ;

4.3.“**Хангалтгүй**” буюу 50 хувиар (**удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, төсөө хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй нь баримтаар нотлогдсон**) үнэлэгдсэн 2 арга хэмжээ;

4.3. “**Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй**” 3 арга хэмжээ байгаагаас үнэлэх боломжгүй 2 арга хэмжээ байна. Үүнд:

Арга хэмжээний дугаар	Арга хэмжээ	Шалтгаан
6.5	Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт шалгалт хийх, мэдээ тайланг нэгтгэх;	Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн “Салбарын хяналт шалгалтын талаар авах арга хэмжээний тухай” 115 дугаар тогтоолоор Засгийн газрын 2025 оны 184 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Салбарын хяналт шалгалтын 2026 оны төлөвлөгөө”-ний холбогдох заалтыг хүчингүй болгосонтой холбоотойгоор нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод хийх төлөвлөгөөт хяналт шалгалт цуцлагдсан.
10.3	Нийгмийн даатгалын ерөнхий газраас гаргасан журам, дүрэм, зааврыг эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, хүчингүй болсон актыг хасуулах ажлыг зохион байгуулах;	Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газраас гаргасан, эрх бүхий байгууллагад бүртгүүлэх Захиргааны хэм хэмжээний акт байхгүй байна.

4.5. Цаашид холбогдох газруудтай хамтран гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үр дүнг нэмэгдүүлэх, эрчимжүүлэх, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай 50-70 хувийн гүйцэтгэлтэй 8 арга хэмжээг харуулбал:

70 хувийн хэрэгжилттэй арга хэмжээг харуулбал:

Арга хэмжээний дугаар	Арга хэмжээ	Хэрэгжилт
1.3	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой батлагдсан дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулах;	Тухайн арга хэмжээ нь 3 шалгуур үзүүлэлттэй бөгөөд Албан журмын болон сайн дурын даатгалын хамралт өмнөх оны мөн үеэс өссөн боловч тайлант хугацаанд ажил олгогч, албан журмын болон сайн дурын даатгуулагчийн тооны төлөвлөгөө биелээгүй.
7.2	Нийгмийн даатгалын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа авч дүгнэх, сайжруулах санал боловсруулж, хэрэгжүүлэх;	Салбарын хэмжээнд Нийгмийн даатгалын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг авч ажиллах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй, Portal.ndaatgal.mn цахим хуудсаар авсан гэх судалгааны үр дүнг тооцоогүй, сайжруулах санал боловсруулж, хэрэгжүүлээгүй;
7.3	Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах, сайжруулах, хөгжүүлэх;	Зорилтот түвшиндээ хүрээгүй Дуудлага алдалтын дундаж хувь: - Аймагт 14.1 хувь; - Дүүрэгт 18.6 хувьтай байна
7.11	Нийгмийн даатгалын байгууллагын үзүүлсэн үйлчилгээ, орлого, зарлагыг мэдээлэх “Мэдээллийн цаг”-тай болох;	Нийгмийн даатгалын үйлчилгээ байгууллагын үйл ажиллагааны талаарх тоон мэдээллийг иргэд, даатгуулагч, ажил олгогчдод хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэх, сурталчлан таниулах, нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор “Мэдээллийн цаг”-ийг зохион байгуулах ажлын удирдамжийг боловсруулсан боловч батлагдаагүй хүргүүлсэн мэдээлэл байхгүй,
8.3	Тэтгэвэр, тэтгэмжийн гүйлгээг НД-ын байгууллага цахимаар хийх боломжийг банкуудтай хамтран бүрдүүлэх /CGW/	Төрийн банк болон ХХБ-д байршиж буй байгууллагын дансны хуулгыг банкны системээс автоматаар татан авч, нийгмийн даатгалын мэдээллийн системтэй уялдуулан ашиглах боломжийг бүрдүүлэх хөгжүүлэлтийн ажлыг хэрэгжүүлж, нэвтрүүлэхэд бэлэн болгосон, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн гүйлгээг цахимжуулах зорилтын хүрээнд Хаан банкт хамтран CGW үйлчилгээг ашиглан тэтгэмжийн гүйлгээний мэдээллийг банкны систем рүү цахимаар дамжуулах хөгжүүлэлтийн ажлын хэрэгжилт 30 хувьтай хийгдэж байна.
8.7	Системийн аюулгүй байдал, тасралтгүй үйл ажиллагааг хангаж Үндэсний дата төвд нөөц сервер байршуулах	Мэдээллийн сангийн нөөц хуулбар (READ)-ыг үүсгэн Үндэсний дата төвд байршуулах бэлтгэл ажлыг хангаж, шаардлагатай техникийн тохиргоо, холболтын ажлыг гүйцэтгэсэн. Нийгмийн даатгалын мэдээллийн системийн нөөцийг Үндэсний дата төвд 2026 оны III, IV улиралд багтаан байршуулахаар төлөвлөсөн байна.

50 хувийн хэрэгжилттэй арга хэмжээг харуулбал:

Арга хэмжээний дугаар	Арга хэмжээ	Хэрэгжилт
7.6	Нийгмийн даатгалын байгууллагын ажлын байр, үйлчилгээний орчны стандартыг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих, үнэлгээ өгөх, өөрчлөлт оруулах;	2026 оны 1 дүгээр улиралд 2 аймаг, 7 дүүрэгт байгууллагын ажлын байр, үйлчилгээний орчны стандартыг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих, үнэлгээ өгөх, журамд өөрчлөлт оруулахаар тусгагдсанаас Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт ажилласан.
7.8	Хиймэл оюун ухаанд суурилсан чатбот үйлчилгээг нэвтрүүлэх;	2026 оны эхний хагас жилд бүрэн нэвтрүүлэхээр тусгагдсан. Facebook хуудасны чатбот үйлчилгээг ndaatgal.mn вэб хуудастай холбож, иргэд, даатгуулагчдаас түгээмэл ирүүлдэг асуултад автомат сонголтоор хариулт авах боломжийг бүрдүүлсэн гэх боловч ямар холбоосоор нэвтрэх мэдээлэлгүй, ажил олгогч, иргэд, даатгуулагчийг мэдээллээр хангаагүй, нэвтрүүлсэн үр дүнг тайлагнаагүй, хэзээ нэвтрүүлсэн нь тодорхой бус;

5. Дүгнэлт

5.1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийг **92.8** хувиар дүгнэж **“Бүрэн хангалттай”** гэж дүгнэв.

5.2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт харьцангуй шуурхай, тогтмол хийгдэж байгаа нь зорилт, арга хэмжээний явц, үр дүнгээс харагдаж байгаа боловч зорилт, арга хэмжээ (үр дүн хүлээгдэж байгаа хангалттай, хугацаа болоогүй арга хэмжээ)-г жилийн эцэст зорилтот түвшинд бүрэн хүргэх шаардлагатай байна.

5.3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээний төлөвлөлт өмнөх жилүүдтэй харьцуулахад харьцангуй сайн хийгдсэн боловч зарим арга хэмжээний, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг дутуу тодорхойлсон байна

6. Зөвлөмж

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн дараах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай. Үүнд:

6.1. Хэрэгжилтийн хүрээнд:

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт тогтмол тавьж хэрэгжилт удаашралтай арга хэмжээний шалтгаан нөхцөлийг тодорхойлж, үр дүнг сайжруулах талаар тухай бүр арга хэмжээ авч ажиллах;

6.3. Тайлагналтын хүрээнд:

6.3.1. Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг товч, тодорхой байдлаар хоёр мянган тэмдэгтэд багтаан баталгаажуулж тайлагнах;

6.3.2. Тоон мэдээлэл болон чанарын үзүүлэлт нь бодитой үнэн зөв байх;

6.3.3. Гүйцэтгэлийн тайлан иж бүрэн, бодитой, товч, тодорхой, утга, найруулга, үг үсгийн алдаагүй, байх ёстой хэрэгцээтэй бүхий л мэдээллийг тайланд тусгаж нотлох баримт хавсаргасан байх;

6.3.4. Тайланд шалгуур үзүүлэлт, зорилтот түвшний мэдээлэл болон ажлын явц, цаг хугацаа, үр дүн, төсвийн зарцуулалт, хариуцан гүйцэтгэсэн нэгж, албан тушаалтан, тушаал шийдвэрийн огноо, дугаарыг тодорхой тусгаж тайлагнах;

6.3.5. Жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланд дараах зүйлсийг тайлагнах. Үүнд:

- Мэдээллийг тоон болон чанарын үзүүлэлтээр бодитой тайлагнах;
- Арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй шалтгааныг товч тайлагнах;
- Арга хэмжээний шалгуур үзүүлэлт нь аливаа баталсан төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар бол тус төлөвлөгөөт хугацааны хувьд зөв төлөвлөж үнэлүүлэх, хэрэгжилтийн хувийг тайланд бодитой тусгах;

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан, үнэлгээний товчоог хавсаргав.

--oOo--